

ӨГҮҮЛБЭРИЙН УТГЫН АНГИЛАЛ, ХЭЛЦ ӨГҮҮЛБЭРИЙН ГОЛ БА ҮҮДЭЛ САНААГ ТАЙЛБАРЛАХ

Монгол хэл 12-р анги
Ш улирлын 4-р хичээл
МХБУЗ-ын багш Б.Энэбиш
enebish@must.edu.mn
99003930

ӨГҮҮЛБЭРИЙН УТГЫН АНГИЛАЛ

ХЭЛЦ ӨГҮҮЛБЭР

Дүрслэх ур маягаар бүтнэ

Өвөрмөц хэлц, хэвшмэл хэлц гэж ангилна.

Далд утга санаатай байна.

Хэвшиж тогтсон бүтэцтэй байна.

ХЭЛЦ БУС ӨГҮҮЛБЭР

Дүрслэх ур маягийг хэрэглэхгүй.

Утга санаа нь тодорхой.

Шууд утгатай

Бүтэц дэх үгсийг чөлөөтэй сэлгэдэг.

ХЭЛЦ ӨГҮҮЛБЭР

ӨВӨРМӨЦ ХЭЛЦ /ИЗОМА/

Аль нэг юм үзэгдэл, үйл явцыг нөгөө юм үзэгдэлтэй адил төстэй шинжээр нь зэрэгцүүлэн далд санаагаар адилтгасан өгүүлбэр.

ХЭВШМЭЛ ХЭЛЦ /ФРАЗЕМА/

Юм үзэгдэл, үйл явцын гадаад, дотоод мөн чанарыг оновчтой, товч тодорхой байдлаар илэрхийлсэн далд утгатай өгүүлбэр.

ХЭЛЦ ӨГҮҮЛБЭР

АДИЛТГАСАН ХЭЛЦ
БУЮУ ӨВӨРМӨЦ ХЭЛЦ

ЭС АДИЛТГАСАН ХЭЛЦ
БУЮУ ХЭВШМЭЛ ХЭЛЦ

ОНЬСОГО

ЁГТ ҮЛГЭР

ЗҮЙР ҮГ

ДҮРСЛЭГ ҮГ

ЦЭЦЭН ҮГ

МЭРГЭН ҮГ

СУРГААЛ ҮГ

ОНЧ ҮГ

**ХЭЛЦ ӨГҮҮЛБЭРИЙН ГОЛ БА ҮҮДЭЛ
САНААГ ТАЙЛБАРЛАХ НЬ**



Хаврын тэнгэр шиг ааштай

Үүдэл санаа:

Монгол орны хавар цагийн цаг агаарын байдалд мал ахуйгаа адгуулан амьдрахад ямархуу хэцүү байдгаас үүдсэн санаатай.

Гол санаа:

Ааш зан тогтворгүй, хувирамтгай хүн

**ХЭЛЦӨГҮҮЛБЭРИЙН ГОЛ БА ҮҮДЭЛ
САНААГ ТАЙЛБАРЛАХ НЬ**



Яаравч бүү явган суу

Үүдэл санаа:

Нас барсан хүнийг оршуулах газрыг сонгож шинжихдээ уг газрын энд тэнд нь очиж явган сууж шинжилдэг арга ёстойгоос үүдэж энэ хэлц нь цээр ёсны илэрхийлэл болж үүссэн байна.

Гол санаа:

Аливаа зүйлд яарч түргэдэлгүй уужуу тайван хандах

ХЭЛЦӨГҮҮЛБЭРИЙН ГОЛ БА ҮҮДЭЛ САНААГ ТАЙЛБАРЛАХ НЬ



**Цавын будаа идэх үү, цавуутай толгой тэврэх үү?
Үүдэл санаа:**

**Бурхны ном үзэхээр сахил хүртэж (эхнэр авахгүй),
сүм хийдэд шавилан сууж лам хүн болох уу, эсвэл хүнтэй
эс суусан (үсээ цавуудаж эрд гараагүй нь мэдэгддэг
байсан) хүүхэнтэй ханилж хар болох уу гэсэн санаанаас
үүдэлтэй.**

Гол санаа:

Бурхны мөр хөөх үү, төрийн түшээ болох уу?

ХЭЛЦ ӨГҮҮЛБЭРИЙН ГОЛ БА ҮҮДЭЛ САНААГ ТАЙЛБАРЛАХ НЬ



“Зээрээр мал хийдэггүй, зээгээр үр хийдэггүй”, “Оргүйд орвол охинтой нь дээр”

Үүдэл санаа:

Охин үр бол хүний эхнэр болж, өөр хүний голомтыг сахих үрийг төрүүлэх хувь тавилантайг мэдрүүлсэн утгатай байдаг нь монголчуудын “үрээр хүн хийж, үрээгээр морь хийж” ирсэн уламжлалт ёс заншлаас үүдэлтэй.

Гол санаа:

Нуган үр нутгаа эзэмшинэ, охин үр өнгө шилэгдэнэ.

ХЭЛЦӨГҮҮЛБЭРИЙН ГОЛ БА ҮҮДЭЛ САНААГ ТАЙЛБАРЛАХ НЬ



**Нохой хорих
Үүдэл санаа:**

Энэхүү нэр, үйлийн холбоо үг шууд утгаараа малчин монголчуудын ахуй амьдралын байдлыг нэрлэж тэмдэглэсэн болохыг эхлээд мэдэх, улмаар тэр айлыг нохойгүйг нь лавтай мэдэж байгаа хэрнээ нэг талаар өөрийнхөө ирж буйг мэдэгдэх, нөгөө талаар тэр гэрт хүн байгаа эсэхийг мэдэх зорилгоор, гэрт дөхөж ирээд “Нохой хорь оо!” гэж дууддаг байна.

Гол санаа:

Энэ хэллэг нь “яаж ч чадахгүй” гэсэн гол санаатай болно.

ХЭЛЦӨГҮҮЛБЭРИЙН ГОЛ БА ҮҮДЭЛ САНААГ ТАЙЛБАРЛАХ НЬ



Хийморийг нь ямаа хивэх

Үүдэл санаа:

Энэ хэллэгт орсон хийморь гэдэг үг нь ямар нэг хийсвэр зүйлийн нэр боловч, чухам юуг нэрлэж байгаа нь шууд мэдэгдэхгүй байна. Харин ямаа хивэх гэдэг нь шууд утгаараа ямаа гэгч мал ямар нэг юмыг зажилж хивсэн тухай өгүүлж байна.

Гол санаа:

Унхиа муутай, ажил үйлс нь бүтэлгүйтэх

МОНГОЛ ХЭЛНИЙ ХЭВШМЭЛ БА ӨВӨРМӨЦ ҮГ ХЭЛЛЭГИЙГ УТГЫН
ОЙРОЛЦОО БАЙДЛААР АНГИЛАХ НЬ

1. Амаа тат

- Амаа ухчих шахах
- Олон үгэнд олз үгүй, цөөн үгэнд гарз үгүй.
- Олон үг толгой орооно.
- Дуугүй байснаас бүтэж үхдэггүй.
- Дааганаас унадаггүй, дарваграас унадаг.
- Цээжинд түймэр шатсан ч утааг нь амаараа бүү гарга.

2. Амаа урчих шахах

- Долоон жорын юм донгосох
- Хамар дор хагархай гэсэн шиг
- Хадны цуурай шиг
- Улаан хэлтнийг урдуураа гаргахгүй байх
- Ангасан адуу шиг ам уралдуулах
- Ам хэл нь гүйцэгдэхгүй байх
- Жолоогүй морь шиг

3. Гар татуу

- *Гарын алга дээш нь харуулж үзээгүй*
- *Хүний гар цайлгаж үзээгүй*
- *Авахдаа бөхийж, өгөхдөө гэдийх*
- *Хашир морь шарвагнуур, харамч хүн татгануур.*
- *Нарийндаа хатсан, хорголоо тоолсон*
- *Харамчийн хар тулам*
- *Бэрд царайлсан.*

4. Бардам ам шалдан гуя

- *Үүрээр үнэг, үдшээр мэлхий*
- *Барын толгойгоор эхлээд, могойн сүүлээр шувтрах*
- *Санаа нь саранд, сачий нь газарт*
- *Санаа нь дэлхий, сачий нь мэлхий*
- *Хоосон санаа холхиндог гутал*
- *Төлгөн хуц элгэн хад мөргөх*

5. Буруу ишилсэн сүх шиг

- Тэмээ гэвэл ямаа гэх
- Хүний үг хор болсон
- Зээр гэхэд бөөр гэх
- Зэс гэхэд гууль гэх
- Дөргүй бух мэт
- Зөрүүд ухна шиг

Гэрийн даалгаварт онолын хэсгийг дэвтэртээ тэмдэглээрэй. Гэрийн даалгаврын зургийг enebish@must.edu.mn хаяг руу анги, овог нэр, хичээлийн сэдэв, дугаар зэргийг тодорхой бичиж 2020.03.25-ны дотор зураг хэлбэрээр илгээнэ үү.